



Батлав. Нийслэл дэх Төрийн Аудитын
Газрын дарга, Тэргүүлэх аудитор



С. Энхбаатар
С. Энхбаатар

Батлав. Анхны цэг ХХК-ын
захирал ХХК



Х. Эрдэнээ
Х. Эрдэнээ

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот

№ *20/706*

2018 оны *11* сарын *15* өдөр

Нэг талаас Нийслэл дэх Төрийн Аудитын Газрыг төлөөлж Тамгын дарга Ч.Цагаанхүү /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас Анхны цэг ХХК төлөөлж захирал Х.Эрдэнээ /цаашид гүйцэтгэгч гэх/ нарын хооронд Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлүүдийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. Нийтлэг үндэслэл

Гэрээ байгуулагч талууд захиалагч байгууллагын оффисын 510м² бүхий Соёлын төв өргөөний 4 давхарын 12 өрөө, 5 давхарын 10 өрөөний халаалт, дулааныг сайжруулах ажлыг гүйцэтгэхээр харилцан тохиролцож гэрээ байгуулав.

ХОЁР. Гүйцэтгэгч талын эрх, үүрэг

- 1.1. Гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг 2018 оны 11 сарын 20-ны өдрөөс 2018 оны 12 сарын 03-ны өдөр хүртэл 14 хоногт хийж гүйцэтгэнэ.
- 1.2. Захиалагчын санал болгосон ажлыг гүйцэтгэлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.
- 1.3. Ажлыг гүйцэтгэл дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан хүлээлцэх актаар тэмдэглэл хөтлөн хүлээлгэж өгөх.
- 1.4. Хийсэн ажлын чанарт 3 сарын баталгаа өгч, баталгаат хугацаанд өөрийн зардлаар засвар үйлчилгээг хийнэ.
- 1.5. Гэрээгээр тохирсон ажлын хөлсийг шаардаж авах эрхтэй.

ГУРАВ. Захиалагчийн эрх, үүрэг.

- 3.1. Гүйцэтгэгчид гэрээний дагуу үйчилгээ хийгдэх объектыг нарийвчлан тодорхой гаргаж өгөх
- 3.2. Гэрээт ажлын гүйцэтгэл, явцад хяналт тавьж ажиллах.
- 3.3. Гэрээт ажлын гүйцэтгэлд гэрээнд заагдсан ажлын хүрээнд шаардлага тавих.
- 3.4. Ажлыг гүйцэтгэл дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан хүлээлцэх актаар хүлээж авах.



3.5. Ажлын гүйцэтгэлийн баталгаат хугацаанд гүйцэтгэсэн ажлын доголдлоор засвар, үйлчилгээ хийлгэх эрхтэй.

3.6. Гэрээнд заагдсан нөхцлийн дагуу төлбөрийг барагдуулах үүрэг хүлээнэ.

ДӨРӨВ. Төлбөр тооцоо

4.1. Гэрээний ажлын хөлс нь хавсралтаар баталгаажсан 65 цонхны дулаалга, засвар үйлчилгээ болон 38 паарны халаалтыг сайжруулах ажлын гүйцэтгэлд ашигтай талбайн 1м² тутмыг 18,000 төгрөгөөр тооцож, нийт 510м² талбайн зардалд 9,180,000 /есөн сая нэг зуун наян мянга/ төгрөг байна

4.2. Ажлыг хүлээж авсанаас хойш ажлын 5 хоногт багтаан төлбөрийг 100% барагдуулна.

4.3. Гэрээт ажлын зардлыг гүйцэтгэгчийн Худалдаа хөгжлийн банк 40721888 дансанд бэлэн бусаар шилжүүлнэ.

ТАВ. Бусад заалт

5.1 Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

5.2 Гэрээний үүргийн хэрэгжилтийн талаар маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд аливаа маргаантай асуудлыг Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.


ЗУРГАА. Гэрээ хүчин төгөлдөр байх

6.1. Талууд гэрээнд гарын үсэг зурсан үеэс гэрээ хүчин төгөлдөр болно.

Гэрээ байгуулсан.

Захиалагч талыг төлөөлж:

НТАГ-ын Тамгын дарга


..... Ч.Цагаанхүү

Хаяг.

Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг
8 дугаар хороо, Г.Амарын гудамж,
Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар
Утас 70007734
Факс (976-11) 32 01 54

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

Анхны цэг ХХК-ын захирал

..... Х.Эрдэнээ

Хаяг.

Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг
12-р АОС – 6 – 9 тоот
Утас 99113172

162 ХАН

ИХНЫ ЦС
ХХК

УЛААНБААТАР

НТАГ-ын 2018 оны . . . тоот ажил гүйцэтгэх
гэрээний хавсралт

Гэрээт ажил хийгдэх өрөөнүүдийн жагсаалт

№	Давхар	Өрөөний дугаар	Нэгж хэлтэс	Цонхны тоо	Паарны тоо
1	4 давхар	421 тоот	Гүйцэтгэлийн аудит аудиторууд	6	3
2		422 тоот	Агуулах	Үйлчилгээ хийгдэхгүй	
3		423 тоот	Санхүүгийн аудитын аудиторууд	4	2
4		424 тоот	Санхүүгийн аудитын аудиторууд	4	2
5		425 тоот	Нийцлийн аудитын аудиторууд	6	3
6		426 тоот	Санхүүгийн аудитын аудиторууд	2	1
7		427 тоот	Нийцлийн аудитын дарга	2	1
8		428 тоот	Санхүүгийн аудитын аудиторууд	4	2
9		429 тоот	Санхүүгийн аудитын менежер	2	1
10		430 тоот	Санхүүгийн аудитын менежер	2	1
11		431 тоот	Санхүүгийн аудитын аудиторууд	4	2
12		432 тоот	Хурлын өрөө	8	4
13	5 давхар	516 тоот	Серверийн өрөө	Үйлчилгээ хийгдэхгүй	
14		517 тоот	Уулзалтын өрөө	Үйлчилгээ хийгдэхгүй	
15		518 тоот	Дарга, Тэргүүлэх аудитор	4	2
16		519 тоот	Даргын туслах	1	1
17		520 тоот	Санхүүгийн аудитын дарга	4	2
18		521 тоот	Гүйцэтгэлийн аудитын дарга	2	3
19		522 тоот	Тамгын дарга	2	2
20		523 тоот	Тамгын хэлтсийн ажилчид	4	2
21	524 тоот	Гүйцэтгэлийн аудитын аудиторууд	4	4	
22		525 тоот	Архивын өрөө	Үйлчилгээ хийгдэхгүй	
22	Дүн			65	38



АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АКТ

Улаанбаатар хот

2018.12.05

Нийслэл дэх Төрийн Аудитын Газар болон Анхны цэг ХХК хооронд байгуулсан 2018 оны 2018/06 дугаартай ажил гүйцэтгэх гэрээний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:


1. 4 давхарын 11 өрөөний 11 цонхны шилний наалт резинийг шинэчлэн сольсон,
2. 4 давхарын 8 цонхны нугсыг шинээр сольж тавьсан.
3. 4 давхарын 11 өрөөний 22 паарыг зогсолт хийж, шугмыг угааж цэвэрлэсэн.
4. 5 давхарын 7 өрөөний 16 цонхны шилний наалт резинийг шинэчлэн сольсон.
5. 5 давхарын 12 цонхны нугсыг шинээр сольж тавьсан.
6. 5 давхарын 7 өрөөний 16 паарыг зогсолт хийж, шугмыг угааж цэвэрлэсэн.
7. 4 болон 5 давхарт халаалт ирдэггүй доголдол бүхий 8 паарыг сольж, шинээр суурилуулж тавьсан болно.

Энэхүү ажил хүлээлцэх актаар хийж гүйцэтгэсэн 7 төрлийн ажлын гүйцэтгэлд гэрээний дагуу 2019 оны 03 сарын 05-ны өдрийг хүртэл 3 /гурав/ сарын баталгааг гаргаж байгаа бөгөөд баталгаат хугацаанд чанарын доголдол гарсан тохиолдолд Анхны цэг ХХК 100% өөрийн зардлаар засвар үйлчилгээг хийх болно.

Ажил хүлээлцсэн:

Захиалагч талыг төлөөлж:


Тамгын дарга



Ч.Цагаанхүү

1117145633
УХА0612 9077278

Нярав



Ц.Ариунболд

Анхны цэг ХХК-ын захирал



Х.Эрдэнээ